**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2019 оны 10 сарын 25 өдөр Дугаар А/481 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.4, 10.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.20 дахь хэсэг, Эрүүл мэндийн яамны "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, хүчингүй болгох байгууллагын хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

2019-A-tushaal

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн А/481 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэр, чиглэл, хугацаа

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Тусгай зөвшөөрлийн хугацаа |
|---|---|---|---|
| Шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага | | | |
| 1 | Дипирамид ХХК | Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх | 3 жил |
| 2 | Чинбаян трейдинг ХХК | Эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх | 3 жил |
| 3 | Хайтан арвижих ХХК | Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, хanган нийлүүлэх | 3 жил |
| 4 | Брэйн Бэйс корпорэйшн Монголиа ХХК | Эмнэлгийн хэрэгсэл, протез, дагалдах хэрэгсэл импортлох, хanган нийлүүлэх | 3 жил |
| Нэмэлтээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага | | | |
| 1 | Медика Монголиа ХХК | Мэргэжлээс шалтгаалах өвчний оношлогоо, эмчилгээ | 3 жил |

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн А/431 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох байгууллагын нэр, чиглэл

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл |
|---|---|---|
| 1. | Интимэйт ХХК | Эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх |
| 2 | МДМ мед ХХК | Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх |